



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/85

Хэрлэн сум

Газар өмчлөх захирамжид  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 21.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.57 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил хэрэгжсэнтэй холбогдуулан мөн газар өмчлөх захирамжийн шивэлтийн алдаанаас болж хаяг болон регистрийн дугаар өөрчлөгдсөн газрын хавсралтад дурдсан гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх тухай аймгийн Засаг даргын 2011 оны 225 тоот захирамжийн хавсралтын 5, 2008 оны 243 тоот захирамжийн хавсралтын 8 дэх хэсгийг тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Өөрчлөлт орсон газрын өмчлөгч иргэдийн газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталсугай.

3. Өмчилж авсан газраа кадастрын болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, бусдад эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас зөвшөөрөл авч байхыг газар өмчлөгч иргэдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч /Ц.Идэрбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны  
03 дугаар сарын 22 өдрийн 4/85  
дугаар захирамжийн хавсралт



Д/ Д	Өмчлөгчийн			Өмнөх				Д/ Д	Өмнөх					
				Захирамжийн					Газрын					
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Холбогдох хэсгийн дугаар		Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Газрын төрөл	Хэмжээ /м2/	Байршил	Ашиглалтын зориулалт	Үнэ /Төгрөг/
0	1	2	3	7	8	10	0	11	12	13	14	14	16	17
1	Бямба	Цоптэрэл	СЮ61022272	2011.07.07	а/225	1	5	2311000004	630	Өөрийн өмчлөл	642	1-р Хийд, 5-14 тоот	Гэр бүлийн хэрэгцээ	1260000
2	Баямаа	Отгонбаатар	СЭ76042974	2008.08.20	243	1	8	221604205	516	Өөрийн өмчлөл	403	2-р баг, Нисэх2-01а тоот	Гэр бүлийн хэрэгцээ	1032000